2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллага Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны 29 ажилтан албан хаагчдад “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” тусгай төслийн хүрээнд төлөвлөгдсөн сургалтыг зохион байгуулахад оролцов.

2017 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Нийслэлийн архивын албан хаагчдад Газар хөдлөлт Объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 3 цагийн сургалтыг

2017 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Газар хөдлөлт, Объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээсэдэвт 1:30 минутын танхимын сургалтыг Ийст гарден интернэшнл ххк-ны 13 ажилтанд сургалтыг зохион байгууллаа.

2017 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Голомт банкны 130 ажилтан албан хаагчдыг хамруулан нийт 10 цагийн танхимын сургалтыг

2017 оны 08 дугаар сарын 18-нд Чингэлтэй дүүргийн 7 хороонд Гамшигт тэсвэртэй Улаанбаатар төслийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтад тус хорооны 18 хэсгийн ахлагч өрхийн эмнэлэгийн ажилтанг хамруулсан 6 цагийн сургалтыг зохион байгуулсан.

2017 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, нутгийн иргэдэд түшиглэн гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд Гамшигт тэсвэртэй Улаанбаатар төсөл хэрэгжиж байгаатай холбогдуулан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, аргачлал боловсруулах тухай” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтыг дүүргийн сайн дурын бүлэгтэй хамтран тус хорооны хэсгийн ахлагч, иргэдийн нийтийн хурлын төлөөлөгч, зохион байгуулагч, мэргэжилтэн, дүүргийн ЭМН-ийн төлөөлөл, өрхийн эмнэлэгийн ажилтан, хорооны ахмад настнуудыг хамруулж, 6 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар гамшгийн эрсдлийн үнэлгээний хийх аргачлалыг тайлбарлан тодорхой ойлголт, заавар өгсөний дагуу аюул, эмзэг байдал, эрсдлийг тодорхойлох зураглал хийн үнэлгээг гаргаж, багаар ажиллах дадлага сургууль хийсэн.

2017 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын Гэрч хохирогчдыг хамгаалах хэлтсийн 24 албан хаагчдад, гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Бишрэлт” ХХК-ний 34 ажилтан албан хаагчдад Гамшиг осол, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын болон гал унтраагуураар ажиллах дадлагын 1 цагийн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 06-ны өдөр “Туул ариажих өргөө” ХХК-ний 17 ажилчдад Гамшиг осол, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын 1 цагийн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 222 дугаар цэцэрлэгийн 15 багш ажилчдад Гамшиг осол, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын 1 цагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

2017 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Гамшиг осол, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын болон гал унтраагуураар ажиллах дадлагын 2 цагийн сургалтыг “Бишрэлт” ХХК-ийн 40 ажилтан, албан хаагчдад,

2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Монголиан ньос чаннел” ХХК-ний 22 ажилчдад цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 02-нд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 55 ажилчдад аливаа аюулаас урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн анхан шатны тусламжийн талаарх арга хэмжээ” сэдэвт 3 цагийн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн

дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа уурын зуухны галч 23 ажилтанд цахилгааны аюулгүй байдлыг хангаж, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр “Монгол оймс” ХХК-ний 25 ажилтан, “Наран туул-2” ХХК-ний 52 ажилтан, “Хүчит шонхор ХХК”-ний 25 ажилтанд цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх тус бүр 1, 1 цагийн галын аюулаас урьдчилан сэргийлэх арга зүйн танхимийн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Монгол Улсад тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэлийн талаар ойлголт өгч, гамшгийн аюул, ослын тухай ойлголт, аюулгүй амьдрах зөв дадал хэвшүүлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах анхан шатны мэдлэг, дадлага олгох сэдвээр “Нийслэлийн Иргэдийг Гамшгаас Хамгаалах Сургалтын Төв”-д 09:00 цагаас 13:00 цагийн хооронд зохион байгуулж, сургалтыг нийслэлийн иргэдийг Гамшгаас хамгаалах сургалтын төвийн дарга, хурандаа Г.Хүрэлбаатар, Сургалт сурталчилгаа хариуцсан арга зүйч, ахмад Д.Мягмарцэцэг, сургагч багш, ахлах дэслэгч Ш.Айжан, дэслэгч Г.Золжаргал, энгийн Б.Ням-Осор, Б.Сүхбаатар, Улаанзагалмайн хорооны арга зүйч Т.Бямбахишиг, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Х.Сумъяа нар газар хөдлөлтийн гамшгийн тухай ойлголт, гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл түүнийг ашиглах, утаат орчноос аюулгүй бүсэд гарах, өөрийгөө аврах, нурангид дарагдсан иргэнд Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх сэдвүүдээр 1-19 дүгээр хороодын 177 хэсгийн ахлагч, нийт 196 албан тушаалтанд онол, дадлагын сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 30 ажилчдад аливаа аюул, ослоос урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн анхан шатны тусламжийн талаарх арга хэмжээ сэдэвт 2 цагийн дадлага сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Үндэсний Аудитын газрын 42 ажилчдад аливаа аюулаас урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн анхан шатны тусламжийн талаарх арга хэмжээ сэдэвт 2 цагийн дадлага сургалтыг тус тус зохион байгуулж ажиллалаа.

- Тайлант хугацаанд Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан ажилтны сургалтыг 56 байгууллагын **1442** ажилтан албан хаагчдыг хамруулан 36 удаагийн 69 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Оюутан сурагчдын сургалт:

2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Чингэлтэй дүүргийн 24 дүгээр дунд сургууль дээр “Гамшиг осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 2 цагийн танхимийн сургалтыг зохион байгуулж явуулав. Сургалтанд тус сургуулийн 62 багш, ажилчид оролцов. Сургалтын хүрээнд “Мэдлэгээ түгээцгээе! Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулахад олон нийтийн оролцоо ба хариуцлага” сэдэвт үндэсний семинарын талаархи мэдээлэл хийж, “Гамшиг осол, аюулт үзэгдлийн тухай ойлголт, газар хөдлөлт, хот суурин газрын онцлог /магнитуд, баллын ялгаа/”, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлж сургуулийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ” сэдвүүдээр сургалт явуулж “Аливаа гамшгийн үед авах арга хэмжээ” брошур 90 ширхэгийг тараасан.

2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Чингэлтэй дүүргийн 17 дугаар сургууль дээр “Гамшиг осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 2 цагийн сургалтыг тус сургуулийн 72 багш, ажилчдыг хамруулан зохион байгууллаа. Сургалтаар гамшиг осол, аюулт үзэгдэл болон газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсролын байгууллагад төлөвлөж хэрэгжүүлэх талаар анхан шатны мэдлэгийг олгож, “Аливаа гамшгийн үед авах арга хэмжээ” зөвлөмж 100 ширхэгийг тараасан.

2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан удирдамж, сургалтын төлөвлөгөөний дагуу Өсвөрийн улаан загалмайн клубын гишүүн

Чингэлтэй дүүргийн 49 дүгээр дунд сургуулийн Н.Уранчимэг багштай 8"А" ангийн 18 сурагчдад "Гамшиг осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хорооны сургалтыг

2017 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Чингэлтэй дүүргийн Улаан загалмайн хорооны сургалтын танхимд Өсвөрийн улаан загалмайн клубын гишүүн Чингэлтэй дүүргийн 49 дүгээр дунд сургуулийн Н.Уранчимэг багштай 8"А" ангийн 24 сурагчдад "Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, аюул тохиолдсон үед авах арга хэмжээ" сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг

2017 оны 03 дугаар сарын 21-ны өдөр Чингэлтэй дүүргийн 23 дугаар дунд сургууль дээр "Гамшиг осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, сургалтад тус сургуулийн 91 сурагч, 5 багш оролцсон сургалтыг

2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн 117 дугаар дунд сургууль дээр 41 сурагчдын сургалтыг

2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр "Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд" сургуулийн нийт 38 оюутнуудад "Газар хөдлөлтийн гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт 1 цагийн сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Улаанбаатар Эрдэм" их сургуулийн 81 оюутныг хамруулан "Газар хөдлөлтийн гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг.

2017 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Шинэ иргэншил" дээд сургуулийн 35 багш, ажилтан, оюутныг хамруулан "Газар хөдлөлтийн гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ" сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороонд байрлах Соёл Урлагийн Их сургуулийн нийт 73 оюутанд газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх сэдвээр хийсэн сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 18-ний өдөр хот суурин газрын газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд цугларах сургуулиас гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны 5 дугаар сургууль дээр зохион явуулж 54 багш, 1208 сурагч, 17 ажилтны сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 18-ний өдөр чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны 39 дүгээр сургууль дээр газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, багш ажилчид газар хөдлөлт гамшгийн нэгдсэн дохиогоор ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион явуулж 63 багш, 521 сурагч, 27 ажилтны сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 18-ний өдөр чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны 49 дүгээр сургуулийн 54 багш, 565 сурагч, 28 ажилтан хамруулан Хот суурин газрын газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, газар хөдлөлт гамшгийн үед сургуулиас гарах цугларах талбайд цугларах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг

2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны 61 дүгээр сургуулийн 349 сурагч, 64 багш ажилтангуудыг хамруулан хот суурин газрын газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, газар хөдлөлт гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд цугларах сургуулиас гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг

2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Тусгал дунд сургууль дээр хот суурин газрын газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, багш ажилчид газар хөдлөлт гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд цугларах

сургуулиас гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион явуулж 26 сурагч, 20 багш ажилтан хамрагдсан сургалтыг

2017 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Атланта дунд сургууль дээр 112 сурагч, 12 багшийг хамруулан хот суурин газрын газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд цугларах сургуулиас гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг

2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 24 дүгээр сургуулийн 845 сурагч, 44 багш, 17 ажилтанд газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, газар хөдлөлт гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг

2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр 72 дугаар сургуулийн 349 сурагч, 64 багш, ажилтанд газар хөдлөлтийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх, газар хөдлөлт гамшгийн нэгдсэн дохиогоор цугларах талбайд гарах дадлага чадварыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг тус тус зрхион байгуулсан байна.

2017 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хэлтсийн даргын баталсан удирдамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Чингэлтэй дүүргийн 140 дүгээр бага сургууль дээр “Гамшиг осол, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг 50 сурагч, 19 багш ажилчдыг хамруулан зохион байгуулав.

- Тайлангийн хугацаанд нийт 18 удаагийн 19 цаг, Гамшиг осол, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг их дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн **457** багш, 227 оюутан, **5563** сурагчдад нийт 6247 хүнийг хамруулан зохион байгуулсан.

Ард иргэдийн сургалт:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд цахилгааны үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”, Эрчим хүчний сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын байгуулсан санамж бичгийн хүрээнд нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг тэглэх болсонтой холбогдуулан Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлтсийн даргын баталсан “Галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан хуваариар Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зохион байгуулав. Үүнд:

2017 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны хэсгийн ахлагч, иргэд 27 хүнд Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг

2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны хэсгийн ахлагч, иргэд 40 хүнд Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх сэдэвт 1 цагийн арга зүйн сургалтыг

2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны хэсгийн ахлагч, иргэд 23 хүнд Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх сэдэвт 1 цагийн арга зүйн сургалтыг

2017 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны “Хүчит шонхор” худалдааны төв дээр зохион байгуулсан Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд 11 дүгээр хорооны Иргэний танхимд тус хорооны хэсгийн ахлагч, иргэд 31 хүнийг хамруулан “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлтсийн даргын баталсан “Галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан хуваариар Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зохион байгуулав. Үүнд:

2017 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж галын аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны Иргэний танхимд зохион байгуулж 9-р хорооны хэсгийн ахлагч иргэд 27 хүн хамрагдсан.

2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж галын аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулав. Сургалтанд 10-р хорооны хэсгийн ахлагч, иргэд 34 хүн хамрагдсан.

2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж галын аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулав. Сургалтанд 17-р хорооны хэсгийн ахлагч, иргэд 57 хүн хамрагдлаа.

2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ-өөс зохион байгуулсан “Өрхийн бэлэн байдал” сэдэвт сургалтын хүрээнд Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны 54 иргэнд “Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг 18 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулсан.

2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ-өөс зохион байгуулсан “Өрхийн бэлэн байдал” сэдэвт сургалтын хүрээнд Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны 42 иргэнд “Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг

2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ-өөс зохион байгуулсан “Өрхийн бэлэн байдал” сэдэвт сургалтын хүрээнд Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны 42 иргэнд “Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ-ийн хурлын танхимд зохион байгуулав.

2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 1 цагийн танхимын сургалтыг 3 удаа Чингэлтэй дүүргийн 14,15,19-р хороодын иргэдийн танхимд тухайн хороодын иргэд, хэсгийн ахлагч нийт 111 хүнийг хамруулан зохион байгуулж явуулсан.

2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Чингэлтэй дүүргийн 16-р хорооны хорооны хэсгийн ахлагч, иргэд 25 хүнийг хамруулан “Цахилгааны аюулгүй байдлыг хангаж гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 1 цагийн сургалтыг

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Хэлтсийн даргын баталсан “Галын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан хуваариар Гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зорион явууллаа. Үүнд:

2017 оны 02 дугаар сарын 20-ний өдөр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны түвшинд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллагын албан хаагчид Гамшгийн тухай ойлголт, Улаанбаатар хот болон Чингэлтэй дүүргийн гамшгийн нөхцөл байдал сэдвээр 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх 6-р төвийн ажилтан албан хаагчид. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтууд,

Газар хөдлөлт ба гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, аюул тохиолдсон үед авах арга хэмжээ сэдвээр

2017 оны 2 дугаар сарын 22-ны өдөр “Наран бьюти уорлд” ХХК-ийн Наран центр Ив рошегийн сургалтанд “Наран бьюти уорлд” ХХК-ийн ажилтан албан хаагчид хамрагдаж

Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтууд, Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, аюул тохиолдсон үед авах арга хэмжээ сэдвээр

2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр “Тусгал” бүрэн дунд сургууль дээр зохион байгуулсан. Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хууль, Олон нийтэд тулгуурлан гамшгийн эрсдлийг бууруулах үндэсний хөтөлбөр болон “Мэдлэгээ түгээцгээе! Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулахад олон нийтийн оролцоо ба хариуцлага” сэдэвт үндэсний семинарын талаархи мэдээлэл тус тус зохион байгуулж явуулсан.

2017 оны 3 дугаар сар 13-ний өдөр Чингэлтэй дүүргийн 11-12 дугаар хорооны иргэдэд Гамшгийн тухай ерөнхий ойлголт олон нийтийн оролцоо, Өрхийн цахилгааны аюулгүй байдал, өрхийн бэлэн байдал анхаар аппликейшныг гар утсанд хэрхэн суулгаж ашиглах талаар зөвөлгөө өгч нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалтыг

2017 оны 03 дугаар сар 13-ний өдөр Чингэлтэй дүүргийн 9-10 дугаар хорооны иргэдэд Гамшгийн тухай ерөнхий ойлголт олон нийтийн оролцоо, Өрхийн цахилгааны аюулгүй байдал, өрхийн бэлэн байдал анхаар аппликейшныг гар утсанд хэрхэн суулгаж ашиглах талаар зөвөлгөө өгөн нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалтыг

2017 оны 03 дугаар сар 14-ний өдөр Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны 34 иргэдэд Гамшгийн тухай ерөнхий ойлголт олон нийтийн оролцоо, Өрхийн цахилгааны аюулгүй байдал, өрхийн бэлэн байдал анхаар аппликейшныг гар утсанд хэрхэн суулгаж ашиглах талаар зөвөлгөө өгөн аливаа гамшгийн үед авах арга хэмжээ гарын авлага тараан ажиллав.

2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр “Тайваны хүүхэд гэр бүл дэмжих сангийн хөтөлбөр”-т бүртгэлтэй иргэдэд “Объектын гал түймэр, ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ” сэдэвт 1:30 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 22 иргэн хамрагдсан.

2017 оны 03 дугаар сарын 29-ны өдөр Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны Аж ахуй нэгж байгууллагын, галын аюулаас урьдчилан сэргийлэх ойлголт гамшгийн үеийн олон нийтийн оролцоо сэдэвт 1 цаг 30 минутын арга зүйн сургалтыг хорооны 43 иргэнд танхимийн сургалтыг зохион байгуулж явуулав.

Ард иргэдийн сургалтыг нийт 68 иргэнийг хамруулан 1 удаа 5 цагийн сургалтыг

Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойн арга хэмжээнд “ Иргэдийн баяр”-ыг зохион байгуулсан. Гамшгаас урьдчилан сэргийлэх, алба сурталчлах арга хэмжээг зохион байгуулж нийт 2000 гаруй иргэдэд сурталчилгааны материал 530 тараасан байна.

2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа газар, хэлтэс, албадын ажилтан, алба хаагчдад гамшгаас хамгаалах талаар мэдлэг эзэмшүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилготойгоор хийгдсэн нийслэл, орон нутгийн цахим сургалтад Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас 20, нийслэл болон орон нутгаас 65, нийт 85 иргэнийг хамруулан 2 цагийн сургалтыг,

2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 197 иргэдийн 5 удаагийн 5 цагийн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 12-ны өдөр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд Гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад тус хорооны хэсгийн ахлагч, өрхийн эмнэлэгийн ажилтанг хамруулан нийт 30 иргэнд 6 цагийн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хэлтсийн даргын баталсан удирдамж, сургалтын төлөвлөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны хэсгийн ахлагч, иргэд 24 хүнд гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх ойлголт гамшгийн үеийн олон нийтийн оролцоо сэдэвт 1 цагийн арга зүйн сургалтыг тус тус зохион байгуулсан.

2017 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 9 дүгээр хорооны хэсгийн ахлагч, иргэд, нийт 24 гэр хорооллын айл өрхөд цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх ойлголт, гамшгийн үеийн олон нийтийн оролцоо сэдэвт 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 12 дугаар хорооны жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 23 иргэнд, цахилгааны аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх ойлголт, гамшгийн үеийн олон нийтийн оролцоо сэдэвт 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 10 дугаар хорооны 26 иргэн, хэсгийн ахлагч нарыг хамруулан, гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 10 дугаар сарын 31-ний өдөр 11 дүгээр хорооны 35 иргэн, хэсгийн ахлагч, нарыг хамруулан, дүүргийн сайн дурын хэсэгтэй хамтран гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр 13 дугаар хорооны нийтийн байр түрээслэгч 27 иргэнд цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 13 дугаар хорооны 46 иргэн, хэсгийн ахлагч нарыг хамруулан, дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн танхимийн сургалт болон гал унтраах дадлагыг,

2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр 14 дүгээр хорооны 27 иргэн, хэсгийн ахлагч нарыг хамруулан, дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн танхимийн сургалтыг,

2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 15 дугаар хорооны 62 иргэд, нийтийн эргүүлүүдийг хамруулан гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх 2 цагийн сургалтыг “Улаанбаатар цахилгаан түгээх” Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв” “Дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-тэй хамтран зохион байгуулсан.

2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хэлтсийн даргын баталсан удирдамжийн хэрэгжилтийг хангах чиглэлийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны 37 иргэн, хэсгийн ахлагч нарыг хамруулан, дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэгтэй хамтран гэр хорооллын айл өрхийн цахилгааны аюулгүй байдлыг хангуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх 1 цагийн арга зүйн танхимийн сургалтыг “Улаанбаатар цахилгаан түгээх” Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв” “Дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг”-тэй хамтран зохион байгуулсан.

- Тайлант хугацаанд: Ард иргэдийн сургалтыг 45 удаа нийт 1572 иргэнийг 68 цагийн сургалтанд хамруулсан.

Бие бүрэлдэхүүний сургалт:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын албаны сургалтын бодлого”, “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг зохион байгуулах ерөнхий журам”, “Бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийг шалгаж үнэлэх заавар”, 2017 оны сургуулийн жилийн удирдамж”-ийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын

хэлтсийн бие бүрэлдэхүүнд 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр 10 цагт Чингэлтэй дүүргийн онцгой байдлын хэлтсийн дарга хурандаа Я.Жаргалсайхан танилцуулан нээлтийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Нийслэлийн онцгой байдлын газрын санхүү хангалт үйлчилгээний албаны дарга, онцгой байдлын дэд хурандаа Д.Урантулга 2017 онд хичээл зохион байгуулах талаар, Бэлтгэл хурандаа Ч.Цогтбаяр, О.Ганхуяг нар галын байгууллагын үүсэл хөгжлийн талаар, Гал унтраах 10 дугаар ангийн захирагч онцгой байдлын дэд хурандаа Ж.Оргодол Гал түймрийн тухай ойлголт, Гал түймэр унтраах дүрмээр хичээл орсоноор алба хаагчдын хичээл сургалтын жилийг эхлүүлсэн.

Төлөвлөгөөт өдөр тутмын дасгал сургууль

346 удаа 692 цаг 6920 алба хаагч хамрагдсан.

Бие бүрэлдэхүүний сургалтыг 7 хоног бүрийн “Лхагва” гарагт Гамшгийн менежмент, Аюулгүй байдал, эрх зүй үндэс, Эрүүл мэнд- сэтгэл зүйн бэлтгэл, Ёс зүйн хүмүүжил, Цэргийн хэрэг жагсаалын бэлтгэл, Биеийн тамирын бэлтгэл, Гадаад хэлний бэлтгэл, Тусгай бэлтгэл.

Шүүлэг

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах, аврах 10 дугаар ангийн бие бүрэлдэхүүнээс Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, Гал унтраах дүрэм, Хорт хий утаанаас хамгаалах талаар дагаж мөрдөх дүрмийн шалгалтанд 715 албан хаагч хамрагдаж

ГТУ-х дүрмээр А-240, В-260, С-215,

ХХАА-ны дүрмээр А-217, В-285, С-232,

ХХУХТДМ дүрмээр А-224, В-276, С-231 үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Гал унтраах норматив дасгалын шүүлэгт давхардсан тоогоор 331 алба хаагчаас А-73, В-148, С-110 үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Бие бялдарын шалгуур үзүүлэлтээр давхардсан тоогоор 240 албан хаагчаас А-95, В-85, С-60 үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тархалтын сургууль:

1-р салаа Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо Засгийн газрын 11 дүгээр байрны хурлын танхимийн хажуугийн 2х3 хэмжээтэй узелийн өрөөнд гарсан гал, Баянгол дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “NOTS” ХХК-ны хөөсөнцөр, сэндвичний үйлдвэрт гарсан гал, Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо Дэнжийн 19-484 тоотод иргэн Ж.Энхбадрахын 8х8 хэмжээтэй байшин, 6х8 хэмжээтэй грашд гарсан гал, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо Зүүн ард аюушийн 7-206 тоотод иргэн Ц.Янжмаагийн 10х20 хэмжээтэй 1 давхар байшинд гарсан гал, Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо Ногоон талбайн 6-36а тоот иргэн Д.Мөнхбаатарын 8х6 хэмжээтэй байшинд гарсан гал, Чингэлтэй дүүргийн 11-р хороо Нуурын 19-415 тоотод иргэн Тулгын 7х6 хэмжээтэй байшингийн дээвэрт гарсан гал, Баянгол дүүргийн 3 дугаар хороо “Барс” захын хогийн цэгт гарсан гал, Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо Хувьсгалчдын Г-ын 277 тоотод иргэн Д.Мөнхбаганы 2х2-2х3 амбаарт гарсан гал, Баянгол дүүргийн 3 дугаар хороо “Барс” захын хогийн цэгт, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо “Broadway” ресторанд гарсан гал гарсан гал, Баянгол дүүргийн 3-р хороо “Ариун-Очир” ХХК-н 2 давхар барилгад гарсан гал, Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо Дунд дарь эхийн 16 дугаар гудамж 824 тоотод оршин суугч иргэн М.Анарын 10х8 хэмжээтэй байшингийн дээврийн хэсэг, 8х5 хэмжээтэй гражид гарсан гал,

2-р салаа Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо Дарь-эхийн 14-р гудамж 438 тоот иргэн Баатарбилэгийн 6х13 хэмжээтэй байшинд гарсан гал, Баянзүрх дүүрэг 27-р хороо Сэлбэ 17-р гудамж 409, 412, 413 тоотуудад 0,2 га өвс шатсан гал, Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороо Баруун тасганы А-9 тоот иргэн Б.Батбаярын 10х16 хэмжээтэй 2 давхар 14 айлын нийтийн орон сууцны 2 давхарт 2х3 хэмжээтэй 3 өрөөнд гарсан гал, Сүхбаатар дүүргийн 4-р хороо Алтайн Б-162 иргэн Г.Уянга 8х10 байшинд гарсан гал, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо “Well mart” худалдааны төвд гарсан гал, Баянзүрх дүүргийн 9-р хороо Шар хадны эцэс Эмнэлэг”-ийн 1-р гудамж 1 а тоот иргэн А.Гантулгын 12 айлын 14х18 хэмжээтэй 2 давхар мансардтай байшин, Баянзүрх дүүргийн 24 дүгээр хороо 65 дугаар ангийн хашаан дотор 00 тоотод 12х5 хэмжээтэй 1 давхар байшинд гарсан гал, Баянгол дүүргийн 23 дугаар хороо зүүг зүүн “Ард Аюушийн” 9-212а тоот иргэн Г.Магнайжавын 10х10 хэмжээтэй 3 давхар байшинд гарсан гал, Баянзүрх дүүргийн 22-р хороо 22-р гудамж 268 тоот иргэн М.Улаанбанди 4х6 байшин, 227 тоот иргэн Ч.Өлзийбаярын 4х7 байшин, 286 тоот иргэн Э.Цэндсүрэнгийн 8х7 байшинд гарсан гал, Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо ХСИС-ээр дээшээ өгсөөд модны үйлдвэр шатаж байна гэсэн Гал унтраах, аврах 63 дугаар ангийн

нэмэлт дуудлагаар 1-р тасаг хүрэлцэн очиход ЗХ-ний 026 дугаар ангийн задгайд иргэн Э.Буянбатын “Өнөөгийн гэр” ХХК-ний гэрийн модны 28х24 хэмжээтэй 1 давхар баамын байшингийн дээврийн хэсэгт гарсан гарсан гал,

3-р салаа Сонгино хайрхан дүүргийн 11-р хороо Овоотын 8-243 тоот иргэн Хүрэлтулга-ын 8х5 хэмжээтэй байшин, амбаар, хашаанд гарсан гал, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо 12 айлын 3 га газрын өнжмөл шар өвс шатаж иргэн Б.Батсайханы 8х7 хэмжээтэй байшин бүрэн шатаж, иргэн Н.Батзоригийн 7х6 хэмжээтэй байшингийн урд хэсэг мөн дээврийн хөндий, 4х6 хэмжээтэй байшингийн гадна хана хайрагдаж, 10х10 хэмжээтэй байшингийн үүдний хэсэгт гарсан гал, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 5 дугаар байрны 2 дугаар орц 2 давхарт 18 тоотод гарсан гал, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо “Сайн international” агуулахад гарсан гал, Сүхбаатар дүүргийн 11-р хороо Рашаан 17-93Б тоот “Амьдралын ус” сүмийн 15х6 хэмжээтэй байшин, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороо иргэн С.Мөнхболдын 10х10 хэмжээтэй байшин болон иргэн Г.Ганболдын 6х8 хэмжээтэй байшингийн дээвэрт гарсан гал, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо Акумо зоне авто засварын үйлчилгээний төвийн тагт болон “Хан өндөр” 8-н нэрийн дэлгүүрийн дээврийн хэсэгт гарсан гал, Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо “Жоби” барилгын материалын дэлгүүрийн хойно цагаан байрны өргөтгөл, иргэн Ц.Батсайханы 11х5 хэмжээтэй барилгын материалын агуулахад гарсан гал,

4-р салаа Баянгол дүүргийн 16-р хороо Туулын 11-р гудамж 208 тоотод оршин суугч М.Машлайн 5х9 м харьцаатай өвлийн сууцны дотор тааз, эд хогшилд гарсан гал, Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо Булгийн 21 дүгээр гудамжны 03 тоот иргэн Д.Ариунбатын 5 ханатай гэр, эд хогшилд гарсан гал, Баянгол дүүргийн 11-р хороо Зүүн нарангийн 10-1 тоот 7х6 хэмжээтэй байшинд гарсан түймэр дээр Гал унтраах тархалтын сургуулийг хийж материалжуулсан. Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо Хангайн 22-790 тоот иргэн Б.Долгорсүрэнгийн 8х7 хэмжээтэй өвлийн сууцны дээвэр, эзэн тодорхой бус 3х4 хэмжээтэй амбаар, WOLKSWAGN маркын 50-28 УНЯ улсын дугаартай автомашины хойд хэсэгт гарсан гал, Сүхбаатар дүүргийн 9-р хороо Алтайн 13-404 тоотод оршин суугч Н.Отгонбадамын 5 ханатай гэр, эд хогшилд гарсан гал, Сонгино хайрхан дүүргийн 30 дугаар хороо Эмээлтийн ноолуурын үйлдвэрт Өгөөж шим ХХК-д гарсан гал, Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо Хувьсгалчдын “Г”-ын 491 тооид иргэн Б.Даваажаргалын 13х5 хэмжээтэй байшинд гарсан гал, Баянгол дүүргийн 12 дугаар хороо 27-р байр 2-р орц 5-н давхар 38 тоотод Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо Нуурын 6-7 тоотод иргэн А.Цэцэндэлгэрийн 7х7 хэмжээтэй байшингийн дотор талд, гарсан гал, Баянзүрх дүүргийн 2-р хороо 20-3 тоотод үйдвэрлэл үйлчилгээ явуулдаг 9х40 харьцаатай “Жодоо мод” нарийн боовны цехийн 5х5 харьцаатай өрөөний таазны хэсэгт гарсан гал, Баянгол дүүргийн 6 дугаар хороо 3-р эмнэлгийн хойно 19б байрны 45 тоот түрээслэгч иргэн Д.Батхуягийн 3х4 хэмжээтэй өрөөнд гарсан гал дээр Гал унтраах тархалтын сургуулийг хийж материалжуулсан.

Тактикийн сургуулийг 5 удаа салааны 199 албан хаагч, тухайн байгууллагын 792 хүн, нийт хүн 991 хамрагдсан.

Тайлант хугацаанд: Гамшгийн эрсдэлийг бууруулах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн арга хэмжээ, сургалтыг Дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, хороодын Засаг даргын ажлын албатай хамтран нийт 10329 иргэдэд, гал түймрийн, аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг гэр хорооллийн 2958 айл өрхөд, урьдчилан сэргийлэх санамж сэрэмжлүүлгийг 21764 ширхэгийг тараан, 51872 иргэнд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх ухуулга сэрэмжлүүлэгийг хийж ажилласан. Үүнээс: ард иргэдийн ажилтны сургалтыг 45 удаа 1572 иргэнийг нэгдсэн арга хэмжээг 24 удаа өдөрлөгийн арга хэмжээг 12 удаа 15592 иргэнийг, аж ахуйн нэгж байгууллагын 36 удаа 1442, Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт 1 удаа 1358, Удирдах бүрэлдэхүүний сургалтыг 11 удаа 228, мэргэжилийн ангийн сургалтыг 10 удаа 606 иргэнийг, Оюутан сурагчдын

сургалтыг 18 удаа 5563 хүүхдийг ухуулга сурталчилгааг 51872 тус тус хамруулан нийт 157 удаагийн дадлага сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Б. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулсан талаар

Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар орон нутгийн телевизэд 2 удаа мэдээ өгч, Онцгой байдлын ерөнхий газрын ontsgoisur.gov.mn сайтад газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсруулсан хичээл 5 оруулж, хэлтсийн вэб сайт, facebook хуудас болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын мэдээллийг 44, телевизэд 21 удаа ярилцага сэрэмжлүүлгийг хийн радиод цаг үеийн холбогдолтой урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг тухай бүрд нэвтрүүлэн байршуулж ажилласан болно.

В. Галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын талаар

Чингэлтэй дүүргийн засаг даргын баталсан “Сүм, хийд, шашны байгууллагад Гамшгаас хамгаалах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх” шалгалтын удирдамжийн дагуу Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа сүм хийд шашны байгууллагуудад тус хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч 2017 оны 02 дугаар сарын 10-наас 02 дугаар сарын 22-ны өдрүүдэд хяналт шалгалт зохион явууллаа. Шалгалтанд нийт 12 сүм, хийд шашны байгууллага хамрагдан нийт 552 зөрчил дутагдал илрүүлж, 85 зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8, Мэдэгдэл 4-ийг бичиж, галын аюулгүй байдал хангаж ажиллаагүй “Ариун гэгээн цуглаан” төвийг Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 25¹-р зүйлийн дагуу 250.000 мянган төгрөгний захиргааны арга хэмжээ авч шалгалтын дүнг нэгтгэн нийслэлийн Онцгой байдлын газарт илтгэх хуудсаар хүргүүлж ажиллалаа.

Чингэлтэй дүүргийн засаг даргын баталсан хүн ам олноор цуглардаг, худалдаа, олон нийтийн байгууллагуудад Галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамж"-ийн хүрээнд тус хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч 2017 оны 02 дугаар сарын 10-аас 02 дугаар сарын 22-ны өдрүүдэд тус дүүргийн 2-р хороо их тойруу 27 тоот Алтжин санаа ХХК, 3-р хороо Номин тав трейд ХХК, 2-р хороо Эрдэнэбулган ХХК, 12-р хороо Хүчит шонхор ХХК, 12-р хороо Нарантуул-2 ХХК зэрэг газруудад хяналт шалгалт хийж нийт 45 зөрчил илрүүлэн илэрсэн зөрчил дутагдалт байцаагчийн зүгээс эрх зүйн бичиг баримт Заавал биелүүлэх албан шаардлага 5ш хүргүүлэн тус шалгалтанд хамрагдсан хүн ам олноор цуглардаг, худалдаа, олон нийтийн байгууллагын нийт 45 ажилтан албан хаагч нарт 4 цагийн гамшгаас хамгаалах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэхталаар танхимийн сургуулийг зохион байгуулан хяналт шалгалтын талаар TV-5, C1 телевизээр тус тус сурталчилан ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Эрүүл мэндийн байгууллагуудад Галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамж"-ийн хүрээнд тус хэлтсийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн нар 2017 оны 05 дугаар сарын 01-аас 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд “Гамшгаас хамгаалах тухай” болон “Галын аюулгүй байдлын тухай” хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт техникийн нормативыг үндэслэн тус дүүргийн 1-19-р хороодын өрхийн эмнэлэг, 4-р хороо Эрүүл мэндийн төв салбар

1, Эрүүл мэндийн салбар 2, Нэгдсэн эмнэлэг, Бага тойруу салбар зэрэг нийт 23 объектод хяналт шалгалт явуулан 168 зөрчил илрүүлж 67 зөрчил буюу 39.8 хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, мэдэгдэл 19, танилцуулга 1-ийг бичиж байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажилласан.

Нийслэлийн Онцгой байдлын газрын дэд даргын баталсан удирдамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөнхийн үсэг ХХК, Монголын үнэт цаас хэвлэл ХХК, Эко пак Монгол ХХК, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын харъяа сонгуулийн тоног төхөөрөмж хадгалах байр, Монгол Ардын Намын Төв байр Тусгаар тогтнолын ордонд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөт шалгалтыг 2017 оны 06 дугаар сарын 02-ний өдөр зохион байгууллаа. Шалгалтаар нийт 5 объект хамрагдаж,галын аюулгүйн норм дүрэм, стандартын заалтыг хэрэгжүүлээгүй 76 зөрчил илрүүлж, 15 зөрчил буюу 19 хувийг газар дээр нь арилгуулан,бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, дүгнэлт 1 бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн санал авах Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 19-н хорооны 47-н хэсгийн хороодын байруудад тус хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч галын аюулгүй байдлыг хангуулах шалгалтыг зохион байгуулан явууллаа. Тус шалгалтад нийт 47 хэсгийн хороодын байр хамрагдаж, нийт 329 зөрчил илрүүлж 180 зөрчил буюу 54.7 хувийг газар дээр нь арилгуулан бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 47 ш, дүгнэлт 47 ширхэгийг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Шалгалтын явцын талаар иргэд, олон нийтэд галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр С-1, TV-8 телевиз, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Газрын тос олборлодог, газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг байгууллагуудад галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамж”-ийн хүрээнд “Гамшгаас хамгаалах тухай” болон “Галын аюулгүй байдлын тухай” хууль, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүйн шаардлагыг тодорхойлсон стандарт техникийн нормативыг үндэслэн батлагдсан хуваарийн дагуу тус дүүргийн 8 дугаар хороо Петро стар ХХК-ийн ШТС-4, 13-р хороо Магнай трейд ХХК-ийн ШТС-2, 19-р хороо Сод Монгол групп ХХК-ийн ШТС-31, 7-р хороо Ойн бирж ХХК-ийн ШТС-39 зэрэг нийт 4 объектыг шалгаж нийт 52 зөрчил илрүүлэн газар дээр нь 14 зөрчлийг арилгуулан бусад 38 зөрчлийг засуулах талаар Заавал биелүүлэх албан шаардлага 4-ийг бичиж холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа.

Мөн “Хүн ам олноор цуглардаг, худалдаа, олон нийтийн байгууллагуудад галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамж”-ийн хүрээнд Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч А.Амартүвшин, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Б.Мягмаржав, сургалт сурталчилгаа урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч Х.Сумъяа нартай хамтран хяналт шалгалтыг зохион байгууллаа. Тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа 68 объект хяналт шалгалтад хамрагдан 476 зөрчил илрүүлж, нийт зөрчлийн 394 буюу 82.7 хувийг арилгуулан, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 21, мэдэгдэл 45, дүгнэлт 8, танилцуулга 1-ийг тус тус бичиж байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын дүрэм, норм

стандартыг зөрчсөн 4 иргэнийг 400.000 төгрөг, 3 аж ахуй нэгж байгууллагыг 3.000.000 төгрөг нийт 7 сүбъектийг 3.400.000 төгрөгийн захиргааны арга хэмжээ авч ажилласан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын харъяа Чингис хаан нисэх онгоцны буудал, техник ашиглалтын байр зэрэг газруудад нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар 2017 оны 10 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хяналт шалгалтыг явуулан галын аюулгүй байдал болон Монгол улсын зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй түрээсээр үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуй нэгж байгууллагад 11 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын баталсан “Авто үйлчилгээний байгууллагуудын Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт норм, дүрмийн хэрэгжилтийг шалгах тухай” удирдамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 01- 28-ны хооронд хяналт, шалгалт зохион явууллаа. Тус хяналт шалгалтанд нийт 18 объект хамрагдаж, галын аюулгүйн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн нийт 124 зөрчил илрүүлэн 13 зөрчил буюу 10.4 хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 14, мэдэгдэл 4-ийг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Нийслэлийн Онцгой байдлын газрын 2017 оны 10/995 тоот албан бичгийн дагуу нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харъяа нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга байгууламжуудад Гамшгаас хамгаалах болон Гал түймрийн улсын хяналт шалгалтыг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр тус газрын нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн орлогч Б.Ууганбат, хууль эрх зүйн мэргэжилтэн А.Батбаатар, цахилгаанчин Ж.Мөнхбат нарыг байлцуулан зохион байгууллаа. Шалгалтаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харъяа нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн нийт 4 объект хамрагдаж, галын аюулгүйн дүрэм, норм, стандартын холбогдох заалтыг зөрчсөн нийт 45 зөрчил илрүүлэн 5 зөрчил буюу 11.1 хувийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлүүдийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4, танилцуулга 1-ийг бичиж, байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч нар дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа 1295 аж ахуй нэгж байгууллагад шалгалт явуулж 8585 зөрчил илрүүлэн, 4603 зөрчил буюу 53,6%-ийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан шаардага 486, мэдэгдэл 502, танилцуулга 19, ажиллагаа зогсоох тогтоол 37, дүгнэлт 184 бичин холбогдох албан тушаалтанд хүргүүлэн Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн, норм стандартын аюулгүй байдлыг хангаагүй 31 аж ахуйн нэгж байгууллагыг 13,050,000 төгрөг, 30 иргэнийг 8,296,000 төгрөг, нийт 61 сүбъектыг 21,346,000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авч ажилласан.

Түүнчлэн дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа галын аюулгүй байдлын норм стандарт хангасан **400** аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож ажилласан байна.

**Гурав. Бэлтгэл бэлэн байдал, гамшигтай
тэмцэх үйл ажиллагаа**

Шинэ жилийн болон сар шинэ, улсын их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх, Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион явуулах зорилгоор албаны өндөржүүлсэн бэлэн байдлын үед үүрэг гүйцэтгэхэд тус хэлтсийн бие бүрэлдэхүүн сахилга, ёс зүйн зөрчил гаргалгүй удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтнуудаас өгсөн үүрэг даалгаврыг зохих ёсоор сайн гүйцэтгэж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Онцгой байдлын газар, Байгаль орчны газрын албан хаагчид, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 31 байгаль хамгаалагчид оролцсон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт дадлагыг Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо Зуун модны зусланд зохион явуулахад тус хэлтсээс 18 албан хаагч оролцсон.

Монгол улсын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой, Сар шинийн баяр болон бусад томоохон арга хэмжээ, зочины хамгаалалтад тус хэлтсээс гал унтраах тасаг гарч жижүүрлэлтийн үүргийг тогтмол хариуцлагатай гүйцэтгэж ирлээ.

2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 07 дугаар сарын 07-ны өдөр хүртэл Гал унтраах аврах 10 дугаар ангийн офицер бүрэлдэхүүн хэлтсийн офицеруудын хамт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дахин санал хураах байр, хэсгүүдээр гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналтаар шалгалтаар явж ажилласан.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын тушаалаар хэлтсийн сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, Х.Сумъяа Үндэсний их баяр наадмаар Хүй долоон худагт худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан 210 аж ахуйн нэгжид 2017 оны 07 дугаар сарын 10-13-ний өдөр хүртэл Сонгино хайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2 офицер, Хууль сахиулах их сургуулийн 4 сонсогч, гал түймэр унтраах аврах 11, 26, 65 дугаар ангийн бэлтгэл ээлжийн бие бүрэлдэхүүн 3 гал унтраах авто машинтайгаар гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр болон цахилгааны галын аюулгүй байдлыг хангах, норм дүрэм, стандартын шаардлага хангасан цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл ашиглах, шингэрүүлсэн хийн тоног төхөөрөмжийн ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар үзлэгийн хийн зөрчлийг газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүй зөвөлгөө өгч ажилласан. Баяр наадмаар 2017 оны 07 дугаар сарын 10,11,12-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талд д/ч П.Чинзориг, д/ч Э.Мөнхбагана, д/ч Л.Энхбат нараар ахлуулсан 2 дугаар тасаг 06-53 УБЯ 10 тонн автомашинтай 24 цаг байрлан үүрэг гүйцэтгэсэн бөгөөд хэлтсийн эргүүлүүд очиж харуул ээлжийг халалцуулж байв. Мөн Хүй долоон худагт наадмын талбайд 07 дугаар сарын 11,12,13-ны өдрүүдэд 10:00 цагаас 20:00 цагийн хооронд 29-53 УБҮ Портер автомашинтай 1 жолооч 2 гал сөнөөгч байрлан үүрэг гүйцэтгэсэн.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны “Ази номхон далайн бүсийн 31 дүгээр жембори”-д галын аюулгүй байдлыг ханган ажиллах тухай А/63 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулж хэлтсийн гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч х/ч А.Амартүвшин батлагдсан хуваарийн дагуу а/а Ч.Батхуяг, а/а Ж.Лхагва-Очир, а/а Б.Батпүрэв, а/а Б.Мягмаржав нар 8 хоног портер автомашинтай Найрамдал зусланд хамгаалалтад гарч ажиллав.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын Аюулгүй байдлыг хангуулах тухай А/64 дүгээр тушаалын дагуу 2017 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Гал унтраах аврах 10 дугаар ангийн а/а Б.Хосбаяр, а/а Б.Батбаяр, а/а Э.Мөнхжаргал, а/ч П.Үүрцайх, д/а Г.Хосбаяр, д/а Н.Махвал нар мицибуши 06-53 УБЯ улсын дугаарын автомашинтай, 08 дугаар сарын 06-ны өдөр а/а Н.Батзориг, а/ч Б.Батхүү, а/а Д.Отгонбаяр, д/а Б.Мягмартулга, д/а Ц.Ган-Эрдэнэ, д/а М.Наурызбай нар Төв цэнгэлдэх хүрээлэнд “Хүрээ цам-даншиг наадам”-ын үеийн аюулгүй байдлыг ханган ажиллаж, хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн.

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Гал унтраах аврах 10 дугаар ангийн нийт албан хаагчдын хөдөлмөр хамгааллын хувцсанд үзлэг хийж, гарсан зөрчлийг арилгуулах талаар салааны захирагч нарт үүрэг өгч, шинээр

томилогдсон болон хөдөлмөр хамгааллын хувцсаар хангагдаагүй 19 албан хаагчид хөдөлмөр хамгаалалын хувцас шинээр олгож, хувийн бэлтгэлийг хангуулж ажиллав.

2017 оны 08 дугаар сарын 25-ны өдөр 19 цагаас 02 цаг хүртэл тус ангийн 1 дүгээр салааны 2 тасгийн албан хаагчид Төв цэнгэлдэх хүрээлэнд “Хуур музик” фестивал хөгжмийн тоглолтын үед галын аюулгүй байдлыг ханган, Ерөнхий зохицуулагчаар хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, дэд хурандаа Д.Цэрэндорж ажиллав.

2017 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр 17 цагаас 00 цаг 30 минут хүртэл тус ангийн 4 дүгээр салааны 8 албан хаагч 2 автомашинтайгаар Төв цэнгэлдэх хүрээлэнд Хурд хамтлагийн “Бид эх орондоо хайртай” тоглолтын үеийн аюулгүй байдлыг ханган 7 цаг 30 минут хамгаалалтад гарч ажилласан.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах ажлын хэсэг томилох тухай” А/75 тоот тушаалын дагуу нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Нямхорлоогоор ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнийг яаралтай түргэн цугларах дохиогоор ажиллуулж, алба хаагчдын хувийн бэлтгэл бэлэн байдал болон аранзны үзлэг хийж ангийн өвөлжилтийн бэлтгэл ажил, Гал унтраах, аврах анги, салааны захирагч нарын хөтлөгдөх бичиг баримтыг шалгаж үүрэг чиглэл өгсөн.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” А/97 тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Гал унтраах аврах 10 дугаар ангийн харуул ээлжийн бие бүрэлдэхүүнд нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Мөнхсайхан, ахлах мэргэжилтэн хошууч М.Батмөнх, мэргэжилтэн ахмад Д.Батзориг, амьсгалын бие даасан төхөөрөмж, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хошууч Э.Буянтогтох, төрийн ордны гамшгаас хамгаалах дарга, хошууч Д.Одонбаяр нар бэлтгэл бэлэн байдлын шалгалт хийн үүрэг даалгавар өгч ажиллав. Шалгалтаар түргэн цугларалтын схем, салаа тус бүрийн утасны жагсаалтад тодотгол хийх, 4 алба хаагч зуны гуталтай, зузаан оймс өмсөөгүй 11 алба хаагч байсныг хугацаатай үүрэг өгч газар дээр нь зөрчил дутагдалыг арилгасан болно.

Яаралтай цуглар дохиогоор ажилласан тухай

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, анги, салбарын бэлэн байдлыг хангуулах тухай” А/28 тоот тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Гал түймэртэй тэмцэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Д.Мөнхсайхан Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийг 2017 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн 07.00 цагт “Яаралтай цуглар” дохиогоор ажиллуулж алба хаагчдын ирц, хувийн бэлтгэл, автомашин техникийн бэлэн байдлыг шалгасан. “ЯЦ” дохиогоор 112 албан хаагч цугларахаас орон тоо дутуу 10, өвчтэй 1, тусгай ажилтай 2, ээлжийн амралттай 15 хүн байж, нийт 82 албан хаагч хамрагдсан.

Хэлтсийн даргаас өгсөн үүргийн дагуу нийт бие бүрэлдэхүүнийг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өглөөний 05:00 цагт “Яаралтай цуглар” дохиогоор ажиллуулж албаны бэлэн байдлыг шалгасан. Үзлэг шалгалтыг Хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, ахмад Б.Чинбат, ангийн орлогч, СХАБ, ахлах дэслэгч А.Батмөнх нар удирдан явуулсан. Нийт 79 албан хаагч хамрагдсан байна.

2017 оны 07 дугаар сарын 30-ны 20 цаг 45 минутанд хэлтсийн орлогч, Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, дэд хурандаа Д.Цэрэндоржийн өгсөн үүргийн дагуу бэлтгэл ээлжийн 10-н албан хаагчийг

“Яаралтай цуглар дохио”-гоор түргэн авч үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажилласан.

Хувцас жагсаалын үзлэг

Тус хэлтсийн Гал унтраах аврах 10 дугаар ангийн бие бүрэлдэхүүний жагсаалын нэгдсэн үзлэгийг 7 хоног бүрийн Лхагва гарагт тогтмол зохион байгуулж ажиллаж байна.

Нийслэлийн Онцгой байдлын газрын 2017 оны 10/326 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангуулж 2017 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 10.00 цагт ангийн жагсаалын талбайд дулааны улирлын хувцасанд шилжүүлэх үзлэгийг зохион байгуулсан.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2017 оны А/234 дүгээр тушаалын дагуу нийслэлийн хүрээний Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын алба хаагчдыг хүйтний улирлын хувцсанд шилжүүлэхтэй холбогдуулан алба хаагчдын нэгдсэн хувцасны үзлэг 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Аврах тусгай ангийн жагсаалын талбайд зохион байгуулахад тус хэлтсийн харуул ээлж болон тусгай ажилтайгаас бусад 84 алба хаагч зөрчил дутагдалгүй хамрагдаж, илтгэх хуудсыг нийслэлийн Онцгой байдлын газарт хүргүүлж ажилласан.

Хэлтсийн алба хаагчдын гал түймэр унтраах хөдөлмөр хамгааллын хувцсанд үзлэг хийж, шинээр томилогдсон болон хувцасны хангалт аваагүй, шаардлага хангахгүй хувцастай 35 алба хаагчид шинээр хувцасны хангалт хийлээ.

Багаж зэвсэглэмж

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 39 автомашин, машин техникт ашиглалтын засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Засварын ажилд нийт 5,1 сая төгрөг зарцуулсан байна.

Техникийн өдөр тутмын болон улирлын техникийн үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэн үр дүнг нь удирдах дээд шатны байгууллагуудад тогтоосон хугацаанд нь илтгэх хуудсаар гаргаж өгсөн. ОБЕГ-ын Хангалт үйлчилгээний ангиас Портер-2 маркийн 29-53 УБҮ улсын дугаартай ой хээрийн түймэр унтраах зориулалттай автомашинд 120 а/ц-ийн багтаамжтай 1 ш аккумуляторыг нөхөн хангалтаар авч албаны бэлэн байдлыг хангуулсан.

Гал унтраах үндсэн албаны ISUZU FTS маркийн 20-86 УНБ улсын дугаартай автомашины багажны хэсгийн тасалгааг авч ёмкостиг нержэн электродоор гагнуулах, ус шахах нацосны 2 ширхэг суурийг солих, перда диск, муфть шарик тохируулах, зүүн хойд дугуйны тоормозны аппаратны поршингийн тохиргоог хийх, хурдны хайрцгийн араа залгах хөшүүргийн мөлхөө тагны шпонкийг авч өөрчлөх, Уаз-22069 маркийн 42-62 УНП улсын дугаартай автомашины хөдөлгүүрийн тахир голыг өнгөлөн иж бүрэн ээлж хийх, шинээр карбюратор, гушитель, яндангийн жийрэг, даруулга, гар карданы наклад, гэрлийн хамгаалалтын суурь, толь, дугуйны колпак, цээж утас, таслан хуваарилагч, маховик, сарзгар диск, чанга яригчийн пульт, 2 ширхэг манангийн шар гэрэл зэргийг шинээр авч тавих, автомашины ачааг авч шинээр шал төмөр сараалж гагнах, перда дискийн цаас солих, таслан хуваарилагчийг тохируулах, заалны суудалыг авч засварлах, автомеханик шатны зориулалттай MAN маркийн 93-17 УБЧ улсын дугаартай автомашины хөдөлгүүрийн тосыг бүрэн солих, Япон улсын ЗГ-ын хөнгөлттэй зээлээр 2003 онд нийлүүлэгдсэн Мицубуши маркийн 06-53 УБЯ улсын дугаартай гал унтраах автомашинд 2017 оны 11 дүгээр сард шинээр нөхөн хангалтаар ирсэн шинэ сэлбэгээс усны радиатор, усны помпыг шинээр тавих, усны ёмкостиг тагийг засварлаж гагнах, цэргийн кабины шалны цоорсон хэсгийг битүүлж засах, араа залгах хөшүүрэг хос тросст засвар хийх, нацос залгах тросс шинээр авах, Ниссан патрол маркийн 45-08 УБЦ улсын дугаартай автомашины чанга яригчийн пульт шинээр тавих, Королла маркийн 06-29 УНЛ улсын дугаартай автомашины 4ш амортизатор, 2ш босоо тэнцүүлэгч, баруун урд гар зэргийг шинээр солих, Портер-2

маркийн 29-53 УБҮ улсын дугаартай автомашины номерийн хайрцагны бэхэлгээ, хийн баллон, ус шахах нацосыг засварлах, урд тэнхлэгийн цохигдож гулзайсан тэвш, рулийн аппаратыг шинээр авч тавьсан зэрэг засвар үйлчилгээний томоохон ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ОБЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу 2017 оны хүйтэний улирлын техникийн үйлчилгээг тусгай төлөвлөгөөгөөр хийж гүйцэтгэн ажлын үр дүнг илтгэх хуудсаар НОБГ-т гаргаж өгсөн.

Уаз-22069 маркийн 42-62 УНП, Мицibuши L-200 маркийн 95-08 УБО улсын дугаартай автомашинуудад ЦЕГ-ын Лицензийн төвөөс тусгай дуут болон гэрлэн дохиог 1 жилийн хугацаатай тавьж хэрэглэх зөвшөөрлийг авч тавьсан.

Ниссан патрол маркийн 45-08 УБЦ, Королла маркийн 06-29 УНЛ улсын дугаартай автомашинуудад тус бүр 40.000 төгрөгөөр багаж түлхүүр авч жолооч нарт хүлээлгэн өгсөн.

Хэлтсийн автомашин техникийн засвар үйлчилгээнд зориулж Кен маркийн гар тасдагч, дрилл зэргийг шинээр авч албаны хэрэгцээнд ашиглаж байна.

Хавар, намрын хуурайшилтын үед ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Уаз-22069 маркийн 42-62 УНП, Портер-2 маркийн 29-53 УБҮ, Ниссан патрол маркийн 45-08 УБЦ улсын дугаартай автомашинуудын ой, хээрийн түймэр унтраах зориулалтын багаж хэрэгслийг асааж шалган бэлэн байдлын хуваарьт оруулсан.

Шинэ жил, Сар шинийн баяр, Үндэсний их баяр наадам зэрэг томоохон тэмдэглэлт баяр, амралтын өдрүүдэд хэлтсийн автомашин техникийн бэлэн байдлыг хангуулж, ажил мэргэжлийн болон техникийн зөрчил, дутагдалгүй ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын шаардлагыг хангах зорилгоор хэлтсийн байр тасалгаа, авто тавиулан, автомашин багаж зэвсэглэмжид 7 хоног бүрийн Пүрэв гарагт "Автомашин багаж, багаж хэрэгслийн цэвэрлэгээ үйлчилгээний өдөр, "Баасан гарагт "Орон байрны цэвэрлэгээ үйлчилгээний өдөр"-ийг тус тус уламжлан болгон явуулж хэвшээд байна. Ангийн захирагчийн батлагдсан төлөвлөгөөний дагуу автомашин, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, үйлчилгээний өдрийг 51, орон байрны цэвэрлэгээний өдрийг 50 удаа тус тус зохион байгуулж, гүйцэтгэл үр дүнг илтгэх хуудсаар авч баримтжуулан ажилласан байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар жолооч бүрэлдэхүүнээс шатны техникч, ахлах ахлагч Б.Болд, гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Б.Батбаяр, Н.Батбаяр, Д.Төрмөнх, Р.Саруулбат, Д.Эрдэнэбат, дэд ахлагч Б.Ууганбаатар, Г.Дарханболд Б.Энхсүх, нар бусдыгаа хошуучлан ажиллалаа.

Тус хэлтсийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар парк ашиглалт 93,3%-тай байна.

Гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэсэн талаар

Гал түймэр

Тус хэлтсийн Гал унтраах аврах 10 дугаар анги нь 294 удаагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлагаар 670 удаа гарснаас 450 гал түймэр дээр байлдааны тархалт хийж, 10 худал дуудлага, 169 гал түймрийг иргэд унтрааж, 20 гал түймэр өөрөө унтарсан, нийт 144 цаг 54 минут ажиллаж, 743,8 тн ус, шатах тослох материал дизель түлш 26531,3 литр, 43,944,732 төгрөгийг зарцуулан 567 иргэн, 208 байшин барилга, иргэдийн 3 тэрбум 811,0 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан байна.

Ой хээрийн түймэр

Төв аймгийн Мөнгөнморьт суманд гарсан ой хээрийн түймэр дээр ахлах дэслэгч Х.Маамуугаар ахлуулсан 12 албан хаагч пургон автомашинтай 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдөр хүртэл 11 хоног үүрэг гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон, Тайл хүдэрийн хоовооцойн ам, Мөнгөлөгийн зоо гэх газарт гарсан ой хээрийн түймэр дээр ахмад В.Мөнхдэлгэрээр ахлуулсан 12 албан хаагч пургон автомашинтай 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдөр хүртэл 9 хоног үүрэг гүйцэтгэв.

Үер усны дуудлага

Дүүргийн 19 дүгээр хорооны 83-р цэцэрлэгийн хашаа үерийн шуудуу хаан таглаж хашаа барьсаны улмаас ойролцоох айл өрхүүд үерийн усанд автаад байна гэсэн өргөдлийн дагуу гал түймрийн улсын хяналтын байцаагч газар дээр нь үзлэг шалгалт хийж, шийдвэрлэж ажиллалаа.

2017 оны 07 дугаар сарын 25-ны өдөр 16:47 минутанд Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо Хувьсгалчдын Б-4-245 тоот хашаанд ус ороод байна гэсэн дуудлагаар а/а Б.Эрдэнэбилэгээр ахлуулсан 3 албан хаагч зөвлөгөө өгч, 16:50 минутанд Чингэлтэй дүүрэг бага тойруу 4 дүгээр хороо 12-А байр 27 тоот иргэн С.Мөнхтуяагийн өгсөн дуудлагын дагуу а/а М.Хүрэлсүх, а/а А.Батпүрэв нар хүрэлцэн очиж 4 цаг граш болон зам дээр тогтсон усыг усны цахилгаан мотор ажиллуулан соруулсан.

Иргэд, аж ахуй нэгжээс ирсэн өргөдөл гомдлын дагуу 15-р хорооны 72-р сургуулиас бохир ус урсаж, 5 давхар орон сууцны зоорийн давхарлуу орж байна гэсэн өргөдлийн дагуу тус хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч газар дээр нь очин үзлэг шалгалтыг хийж, арга хэмжээ авч, мэргэжил арга зүйн зөвөлгөөг өгч ажилласан.

Бусад

2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороонд байрлах 224 дүгээр цэцэрлэгийн 114 метр гүн инженерийн хийцтэй өрөмдмөл худагт эвдрэл гарсан талаар ирсэн мэдээллийн дагуу Онцгой байдлын хэлтсийн дарга, онцгой байдлын хурандаа Я.Жаргалсайханы шийдвэрээр томилогдсон, шалган туслах ажлын хэсэгт хэлтсийн гамшгийн төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн болон гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч нар ажиллан бодит байдлыг газар дээр нь үзэж шалган заавар зөвлөмж өгч ажилласан.

Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Яргайтын 7 дугаар гудамж орчимд хөрсний усны халиа үүсч мөстөн, иргэд болон автомашин зорчиход хүндрэлтэй байдал үүссэн гэсэн дуудлагаар дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат, Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа Я.Жаргалсайхан, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн дарга А. Гэрэлт-Од, Тохижилт үйлчилгээний ХКК-ний захиарл Э.Ганчимэг нар болон албны хүмүүс газар дээр нь танилцаж халиа мөстлөгийг арилгах яаралтай арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болголоо.

Чингэлтэй дүүргийн Засаг даргын өгсөн үүргийн даргуу Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтийн орлогч, дэд хурандаа Д.Цэрэндоржоор ахлуулан 4 албан хаагч, ТҮК-с 8 хүн 1-экскабатор, 3 автомашин ажиллаж сэтэлсэн байна. 2017 оны 11 дүгээр сарын 20-ний өдөр дүүргийн Онцгой байдлын хэлтсээс нийт 5 албан хаагч ажиллаж гүүрэн доор ажиллаж лаг шавар болон хогийг гарган ажилласан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас дэвшүүлсэн “Соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулж, сахилга, дэг журам, ажлын хариуцлагыг сайжруулах” жилийн зорилтын хүрээнд

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2017 оны А/259 дүгээр тушаалын хүрээнд 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Онцгой байдлын албаны Гурван үеийн

чуулга уулзалт”, залгамж чанарыг бэхжүүлѐе арга хэмжээнд гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Б.Мягмаржав, Гал унтраах аврах 10 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Оргодол, тасгийн дарга, ахлах ахлагч Д.Нэргүй, гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Ч.Батхуяг нарын тэргүүний албан хаагчдыг оролцууллаа.

Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд Монгол улсын гавъяат багш н.Түвшинтөгс “Гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн хөгжлийн үндэс” сэдвээр 2 цагийн, G-mobile ХХК-ны технологийн менежер н.Мандхай “Мэдээлэл технологийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлага” сэдвээр 1 цагийн сургалтыг тус тус зохион байгуулж явуулсан.

Долоо хоног бүрийн Лхагва гараг бүр ангийн жагсаалын нэгдсэн үзлэг явуулах хуваарийн дагуу 12 удаа ангийн хувцасны үзлэг зохион байгуулсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Дээлтэй монгол” өдөрлөгийн арга хэмжээнд тус хэлтсийн бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцсон.

Дээрх арга хэмжээний үеэр Онцгой байдлын хэлтсээс албан хаагчдынхаа 162 хүүхдэд бэлэг өгсөн байна

Гал унтраах ангийн “Хөдөлмөр хамгааллын булан”-д хөдөлмөрийн аюулгүй байдлыг сахиж ажиллах талаар 2 төрлийн видео хичээлийг байрлуулсан.

Дөрөв. Санхүү, аж ахуй

А.Батлагдсан төсөв түүний гүйцэтгэл, орлогын талаар

Тус хэлтэс нь 2017 оны 4 дүгээр улиралд батлагдсан төсвөөр 209,092,500 төгрөг батлагдсанаас 210,359,500 мянган төгрөгийн санхүүжилт авч 216,377,950 мянган төгрөгийн зарлага хийгдсэн. Нийт 40,091,418 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2017 оны 4 дүгээр улиралд 210,029,500 төгрөгийн батлагдсан санхүүжилт орж ирсэн.

Мөн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 100200031407 тоот дансанд

- Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/220, А/240, А/337 тоот захирамжаар “Бэлтгэл бэлэн байдлыг хангуулах тухай”, “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх”, “Иж бүрэн дадлага сургуулилт зохион байгуулах тухай” болон “Хөрөнгө гаргах тухай” нийт 3 захирамжийн 30926.6 мянган төгрөгийн санхүүжилт авч зохих зардлыг зарцуулж ажилласан.
- Чингэлтэй дүүргийн засаг даргын А/530 дугаар тушаалаар 1438,0 мянган төгрөг, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын А/54 дүгээр тушаалаар 500,0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, эргүүл, хяналт, шалгалт, гал унтраах техникийн олон төрөлтийн сургалт зохион байгуулах бэлтгэл бэлэн байдлыг хангаж зохих зардлыг зарцуулж ажилласан.
- Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/626, А/627 дугаар захирамжуудаар нийт 3325,5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч малын гоц халдварт шүлхий, цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил болон шуурхай командын бүрэлдэхүүний тэмцээний хоолны зардалд, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны А/103 дугаар тушаалаар 3000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтанд тус тус зарцуулж ажилласан.

2017 оны Засгийн газрын 55 дугаар тогтоолоор батлагдсан 2016 оны сүүлийн хагас жилийн гамшиг ослын томилолт урамшууллын зардалд 7124,0 мянган төгрөг батлагдаж албан хаагчдад олгосон.

2017 оны сар бүрийн төсвийн гүйцэтгэл, жилийн батлагдсан төсөв зэрэг мэдээллийг shilendans.gov.mn цахим хаягт шивсэн.

3 дугаар улирлын байдлаар хүн амын орлогын албан татварын тайлан гаргаж www.mta.mn цахим хаягт илгээсэн.

Б.Цалин хөлс бодолт , олголтын талаар

2017 оны 4 дүгээр улиралд 116 албан хаагчдад 198,863,150 мянган төгрөгийн цалин бодож, нийгмийн даатгалд 5,917,206 төгрөгийг шилжүүлэн ажиллалаа. 2017 оны 04 дүгээр улирлын байдлаар өр авлага үүсээгүй болно. 10 дугаар сард бие бүрэлдэхүүнээс 2 албан хаагчийн ээлжийн амралтын 1668,8 мянган төгрөгийг бодож, биеэр ээлжийн амралтыг эдлүүлээд байна.

Цалинг сар бүрийн 10, 25-нд бодож албан хаагчдын Хас банкны дансаар дамжуулан олгож ажилласан.

В.Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар

Хэлтэс болон Гал унтраах аврах 10 дугаар ангийн шатах тослох материалын тайланг хүлээн авч тооцоо нийлж ажиллалаа.

2017 оны 04 дүгээр улирлын байдлаар нийт 5,1 сая төгрөгийн бараа материалын орлого авч 4,5 сая төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг хасч, няравын бараа материал, үндсэн хөрөнгийн тайланг баталгаажууллаа.

Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хүлээн авсан 5,2 сая төгрөгийн үнэ бүхий машин тоног төхөөрөмжийг хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэх зөвшөөрлийг нийслэлийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу бусад хангамжийн материалын дансанд бүртгэлтэй 21,0 сая төгрөгийн хөрөнгийг машиг тоног төхөөрөмж данс руу шилжүүлэх бичгийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлэн ажилласан.

Тав. Бусад ажил

Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны 03-р сарын 31-ний өдрийн 3/561 дугаар албан бичгийг хэрэгжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах удирдамжийн дагуу 2017 оны 04-р сарын 01-ний өдрийн 10:00 цагт ангийн бие бүрэлдэхүүнийг цуглуулан Чингэлтэй дүүргийн 5-р хороо Гэсэр сүмийн уулзвараас Тасганы овоо хүртлэх нийтийн эзэмшлийн 0,5 км үерийн далан сувагт хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажилд Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн 35 албан хаагч оролцсон бөгөөд захирагч дэд хурандаа Ж.Оргодол, ангийн орлогч СХАБ ахмад А.Батмөнх нар хяналт тавин ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газраас Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэн байгуулагдсаны 95 жилийн ойн нэрэмжит “Онцгой аялгуу” дууны тэмцээн 01-р сарын 13-ний өдөр Леон ресторанд зохион явагдаж ахмад Г.Батжаргал, ахлах дэслэгч Б.Ундрал, ахлах ахлагч Э.Алтаншагай, Б.Мягмартулга, Д.Дулмаа нар амжилттай оролцсон.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын А/41 дүгээр тушаалын дагуу Нийслэлийн Онцгой байдлын газрын харъяа бүтцийн нэгжийн алба хаагчдын дунд 2017 оны “Сагсан бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээн 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан. Тэмцээнд Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн баг тамирчид Тэргүүн байр эзэлж Цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдсан.

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн 4 салааг хамруулан ажил мэргэжлийн тэмцээнийг 2017 оны 05 дугаар сарын 31-ны өдөр 09.00 цагаас 15.00 цагийн хооронд зохион байгуулж явууллаа. ГТУА-10 дугаар ангийн

а/д Х.Маамуу захирагчтай 1 дүгээр салаа 1, д/ч Б.Найдан захирагчтай 2 дугаар салаа 2, а/х В.Мөнхдэлгэр захирагчтай 3 дугаар салаа 3, а/д Ц.Үүрцайх захирагчтай 4 дүгээр салаа 4-р байр эзэлсэн байна.

Нийслэлийн Онцгой байдлын газрын 2017 оны “Марш тактик тусгай бэлтгэл” -ийн аварга шалгаруулах тэмцээн 2017 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр Хүй долоон худагт Улаанбаатар хотын 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс, ангийн 14 багийн 168 тамирчид оролцлоо. Тэмцээний нийлбэр дүнгээр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн баг тамирчид 1-р байранд шалгарч шилжин явах Цом, Өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал, Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн баг тамирчид 2-р байр мөнгөн медаль, мөнгөн шагнал, Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн баг тамирчид 3-р байр хүрэл медаль, мөнгөн шагналаар тус тус шагнагдсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын харъяа хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит, цэргийн гавъяаны улаан тугийн одонт Аврах тусгай ангийн нэрэмжит Сагсан бөмбөгийн тэмцээнд тус ангийн баг тамирчид амжилттай оролцож 3 дугаар байр эзэлж хүрэл медалаар шагнагдсан.

Гал тахиа жилийн сар шинийн баярыг тохиолдуулан албан хаагчдын дунд зохион явуулсан бөхийн барилдааны тэмцээн Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан 2017 оны спортын төлөвлөгөө, 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдөр баталсан Сар шинийн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах тэмцээний удирдамжийн хүрээнд 2017 оны 02 дугаар сарын 22-ны “Аврагч спорт хороо”-ны спорт зааланд зохион байгуулахад 32 бөх зодоглож, шөвгийн дөрвөн бөх уран мэхийг уралдуулан барилдаж сумын заан Ц.Отгонбаяр түрүүлж, сумын заан Б.Баянмөнх үзүүрлэж, 3-р байрт залуу бөх К.Нурлан, 4-р байрт залуу бөх Б.Батмөнх нар шалгарч сар шинийн тавгын идээ, алтан медаль өргөмжлөлөөр шагнагдсан байна.

2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойн баярыг угтаж “Гудамжны баяр”-ын арга хэмжээнд дүүргийн удирдлага, иргэд оролцсон нийт 1500 гаруй хүмүүс баярын жагсаалын үеэр дүүргийн хэлтэс, албад, иргэдэд байгуулгынхаа үйл ажилгааны чиглэлийн дагуу гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ухуулага, сэрэмжлүүлэг гарын авлагыг тараан оролцлоо.

Засаг даргын захирамжаар Онцгой байдлын хэлтсийн албан хаагчдыг Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойн медалиар шагнаж урамшууллаа. Шагнал гардуулах арга хэмжээнд Засаг дарга Ж.Эрдэнэбат, Засаг даргын Тамгын газрын дарга А.Дамцагдорж нар шагналыг гардууллаа.

Гал унтраах техникийн олон төрөлт спортын Улаанбаатар бүсийн 2017 оны аварга шалгаруулах тэмцээн 07 дугаар сарын 04-05-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Баянхошууны сургалтын цогцолборт амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд 13 баг тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм. Тэмцээнд нийслэлийн 16 багийн 128 тамирчин Довтолгооны шат, Саадтай 100 метрийн гүйлт, 4x100 метрийн буухиа гүйлт, Байлдааны тархалт гэсэн 4 төрлөөр өрсөлдөв. Нийслэлийн Онцгой байдлын газрын “Ган дуулга клуб”-ын баг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн нярав, багны засварчин ахлах ахлагч Г.Эрдэнэбаатар ахлагчтай Олон улсын хэмжээний мастер Д.Ганзориг дасгалжуулагчтай Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн баг тамирчид оролцож багаараа 2 дугаар байрт шалгаран “Мөнгөн медаль” Өргөмжлөлөөр шагнуулан энэ тэмцээний Саадтай 100 метр, довтолгооны шатны төрөлд ахлах ахлагч спортын дэд мастер Э.Алтаншагай 1-р байр эзэлж өргөмжлөл алтан медалиар шагнуулав.

Нийслэлийн Онцгой байдлын газрын аварга шалгаруулах “Мэргэжлийн Аврагч-2017” тэмцээн 2017 оны 09 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, тэсвэр хатуужлыг дээшлүүлэх, анги

байгууллагуудын мэргэжлийн бэлтгэлийн төвшинг тодорхойлох, үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааг сайжруулах, гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх зорилготой тус тэмцээнд нийслэлийн Аврах анги, дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах аврах ангиудын нийт 15 багийн 120 гаруй тамирчин оюун ухаан, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргуудаа шалгарууллаа. Дэслэгч Л.Чинзориг ахлагчтай Гал түймэр унтраах, аврах 10-р ангийн баг тамирчид хоёрдугаар байранд шалгарч мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан.

Хурандаа генерал С.Равдангийн мэндэлсний 110 жилийн ой, Цэргийн гавъяаны улаан тугийн одонт ОБЕГ-н харъяа Аврах тусгай ангийн 50 жилийн ойн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн хүрээний Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагуудын албан хаагчдын дунд “Гар бөмбөг”-ийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдахад тус ангийн 8 албан хаагч амжилттай оролцсон.

Нийслэл Улаанбаатар хотын 378 жилийн ойг тохиолдуулан Онцгой байдлын Ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Өсвөрийн аврагч-2017” тэмцээнийг зохион байгуулж, дүүргийн ахлах сургуулийн 11 баг тамирчид 9-н төрлийн тэмцээнд өрсөлдсөнөөс 23 дугаар сургуулийн “Элит” баг тэргүүн байр эзлэн нийслэлийн аврага шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын Гал унтраах аврах 16 дугаар анги үүсэн байгуулагдсаны 40 жилийн ой, ОБАЭБайгууллагын ГУТОТСпортын холбооны клубуудын аварга шалгаруулах тэмцээн Баянхонгор аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тус тэмцээний саадтай 100 метрын төрөлд гал сөнөөгч ахлах ахлагч Э.Алтаншагай 1 дүгээр байр, дэд ахлагч Б.Буянбат 3 дугаар байр мөн 4x100 метрын төрөлд 3 дугаар байр. Нийлбэр дүнгээр “Гуравдугаар” байранд Улаанбаатар бүс “Ган дуулга” клубын баг тамирчид шалгарлаа.

Чингэлтэй дүүрэг үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой, эрүүл мэндийг дэмжих жилийн ажлын хүрээнд төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан дүүргийн Засаг даргын нэрэмжит “Спорт наадам-2017” тэмцээний дартсын аварга шалгаруулах төрөлд хүрэл медаль, гар бөмбөгийн аварга шалгаруулах төрөлд, 2 дугаар байр мөнгөн медаль, Сагсан бөмбөгийн аварга шалгаруулах төрөлд тэргүүн байр алтан медалиар тус тус шагнагдсан байна.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2017 оны А/259 дүгээр тушаалын хүрээнд 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдсан “Онцгой байдлын албаны Гурван үеийн чуулга уулзалт”, залгамж чанарыг бэхжүүлж арга хэмжээнд гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Б.Мягмаржав, Гал унтраах аврах 10 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Оргодол, тасгийн дарга, ахлах ахлагч Д.Нэргүй, гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Ч.Батхуяг нар оролцлоо.

Мөн Онцгой байдлын ерөнхий газрын харъяа төв орон нутгийн газар, хэлтсийн албан хаагчдын 2017 оны аварга шалгаруулах спортын тэмцээн ОБЕГ-ын харъяа “Аврагч” биеийн тамир, техник спортын хорооны зааланд 2017 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус тэмцээнд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын 15 багийн 300 гаруй тамирчид сагсан бөмбөг, сонс эргэлт, бие бялдын ерөнхий хөгжлийн 224 тоот дасгалын төрлүүдээр өрсөлдсөнөөс сонс эргэлтийн төрөлд гал сөнөөгч, ахлагч Б.Төвшинбаяр 2 дугаар байр мөнгөн медаль, бие бялдарын ерөнхий хөгжлийн 224 тоот дасгалын төрөлд гал унтраах аврах 10 дугаар анги 3 дугаар байр эзэлж хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн бөгөөд тэмцээний нээлтийн ажиллагаанд тус ангийн 15 албан хаагч байгууллагын хаяг барьж жагсах, 40 албан хаагч жагсаалын үзүүлэх тоглолт хийж оролцлоо.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2017 оны “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай” А/102 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах

ажлын хүрээнд Давтан сургалт сэргээн заслын төвийн 6 хүний бүрэлдэхүүнтэй эмч нарын баг ирж зүрхний бичлэг, эхо, дотрын үзлэг хийж бие бялдарын шалгалтыг алба хаагч нэг бүрээр хийлгэж зохих мэргэжлийн зөвөлгөөг өгч ажилласан.

Тус хэлтэс орон тоогоор 113 хүн хамрагдахаас 5 хүн чөлөөтэй, 86 алба хаагч хамрагдсан байна. Хамрагдаагүй үлдсэн 22 алба хаагчийг давтан хамруулсан байна.

Дүгнэлт:

2017 онд Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн нийт албан хаагчид албан үүргээ амжилтай биелүүлж, ахлах даргаас өгсөн үүрэг даалгаварыг цаг хугацаанд нь биелүүлж, төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн гэж үзэж байна.

ХЯНАСАН:

ДАРГА,
ХУРАНДАА

Я.ЖАРГАЛСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЭЛТСИЙН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛТГЭЛ
БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
АХЛАХ БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА

Д.ЦЭРЭНДОРЖ

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ:

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийн хүрээнд өдөрлөг зохион байгуулж байгаа нь:



Хороо нэгдсэн арга хэмжээгээр Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтаар



“Өсвөрийн аврагч” тэмцээнийг ерөнхий боловсролын 11 сургуулийн дунд зохион байгуулсан:



Ард иргэдэд Гамшиг осол, гал түймрийн урьдчилан сэргийлэх сургалт хийж байх үед



Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/626 дугаар захирамжаар малын гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх давтан вакцинжуулалт хийж байх үед:



Гамшгийн эрсдэлийг бууруулах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээ



Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо Яргайтын 7 гудамжинд үүссэн мөсний халиа дээр ажилласан байдал



Техник засвар үйлчилгээний ажил хийгдэж байгаа байдал

